



18/

МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1997....оны 12....сарын 09....өдөр

Дугаар 332

Улаанбаатар хот

Гадаадад хүн сургах тухай

ТУШААХ НЬ:

1.Ишдоржийн Ариуныг АНУ-ын Айдохо мужийн Их Сургуульд хэрэглээний математикийн, Цэвээнжавын Батчимэгийг АНУ-ын Пүрдюгийн Их Сургуульд малын генетик-биотехнологийн, ёндөнпэрэнлэйн Баасанжаргалыг АНУ-ын Умарт Каролинагийн Их Сургуульд төрийн удирдлагын чиглэлээр тус тус магистрантурт 1997/1998 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.

2.Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1997 оны 224/268 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гадаад орны магистрантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр хийхийг Сургалтын төрийн сангийн захирал Б.Ганбатад, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Алтангэрэлд тус тус даалгасугай.



САЙД

Ч.ЛХАГВАЖАВ

Ч.ЛХАГВАЖАВ